

АНХНЫ МОНГОЛ СЭТГҮҮЛЧДИЙН НЭГ, ЧИН ЗҮТГЭЛТ ХАЙСАН ГҮН

Д.Норовсүрэн\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

**Түлхүүр үг:** эрдэмт сэхээтэн, сонины найруулагч, баримт сэлт, хэвлэлийн түүх, “Монголын сонин бичиг”, соён гэгээрүүлэгч.

**М**онголчууд ном хэвлэл барлах, туурвин бүтээх эртний уламжлалтай ард түмэн боловч тогтмол хэвлэл гаргаж, сэтгүүлчийн ажил эрхэлсэн нь нэлээд хожуу буюу тодруулбал XIX зууны сүүл хэрд холбогдож байна. Монгол хэлээр гарсан анхны сонинуудад ажиллаж байсан цөөн монгол хүний нэг нь Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын нэрт зүтгэлтэн Баянтөмөрийн Хайсан байжээ.

Тэрбээр 1857 онд Өвөр Монголын Зостын чуулганы Харчин баруун хошууны Хадран улаан ганга гэдэг газар чинээлэг сэхээтний гэрт төржээ. Хайсан бага наснаасаа эхлэн арван дөрвөн жилийн турш гэрийн багшаар манж, монгол, хятад хэлбичиг заалгаж, эдгээр гурван хэлийг төгс эзэмшсэний дээр хожим Харбинд сууж байсан Оросын консул Симоновтой дотно танилцаж орос хэл сурсан байна. Энэ завсар монгол, хятадын эртний утга зохиол, түүх, хууль цаазыг сонирхон судалж,

олон улсын харилцаа, төрийн бодлого, дипломат ёсонд гүнзгий боловсорсон эрдэмт сэхээтэн байжээ.

Б.Хайсангийн амьдрал, үйл ажиллагааг улс төрийн томоохон зүтгэлтэн, ном бичигт цагааширсан эрдэмт сэхээтэн, монгол үндэстний авьяаслаг сэтгүүлч гэсэн гурван чиглэлээр авч үзэж болно. Тэрбээр юуны түрүүнд томоохон улс төрч, төрийн мэргэн бодлоготон байлаа. XIX зууны дунд үеэс Чин улсын засгийн газар «Иргэнийг шилжүүлэн суулгаж, хязгаарыг өрнүүлэн бадруулах» нэрийдлээр Өвөр Монголын нутагт хятад иргэдийг олноор суулгаж, чуулган, хошуудад Хэрэг эрхлэх газруудыг байгуулан шууд ноёрхох бодлого явуулж эхэлсэн юм. Залуу сэхээтэн Хайсан тийм нэг хэрэг эрхлэх газарт ажиллаж, удалгүй Харчин баруун хошууны Вангийн ордонд цэргийн мээрин болж дэвшсэн байна. Энэ үеэс түүний улс төрийн үйл ажиллагаа эхэлсэн байдаг. Хэрэг эрхлэх газрынхан Өвөр Монголд шилжин суурьшсан хятад иргэд ба монголчуудын хооронд газар нутаг, малын бэлчээрээс болж гарсан элдэв маргаан тэмцлийг шийдвэрлэхдээ ямагт хятад хүмүүсийн эрх ашгийг хамгаалж байгаад дургүйцсэн Хайсан



орон нутгийн эрх баригчидтай байнга сөргөлдөж, тэр бүхэнд Манжийн ноёрхлыг эсэргүүцэх үзэл нь лавширч байв. Тэр шударга үйл хэргээсээ болж хавчигдан гадуурхагдах болсон тул 1902 оны үед нутгаасаа дүрвэн гарч, гэр бүлээрээ Харбин хотод очиж суурьшсан байна.

Хайсан Харбинд ямар ажлыг хэдий хугацаагаар эрхэлж байсан хийгээд Монголын Их Хүрээнд ямар хэргээр хэдийд ирсэн тухай судлаачдын бичсэн зүйл нэлээд зөрөөтэй байна. Харбинд байсан Оросын Консулын газарт хэлмэрчээр ажиллаад дөрвөн жил орчим болж байтал консул Симонов «"Гадаад Монгол тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж эхэллээ. Тэнд эрдэм мэдлэгтэй хүн их хэрэгтэй байна. Чи тийшээ оч" хэмээн зөвлөсний дагуу 1907 онд Гадаад Монгол руу явсан» гэж хятадын судлаач Бай Юйкунь бичсэн бол, академич Б.Ширэндэв «Дорнод хятадын төмөр замыг удирдах газраас Харбин хотод гаргаж байсан "Монголын сонин бичиг" хэмээх монгол сонины редактор байжээ» гэж бичсэн мөртөө цаг хугацааг заагаагүй байна. Харин Финляндын монголч эрдэмтэн Рамстедтыг 1909 онд Их Хүрээнд ирэхэд Ханддорж чин ван Өвөр Монголоос ирсэн өндөр нуруутай, цоохор нүүртэй Хайсан гэдэг хүнийг газарчнаар авч явахыг зөвлөхөд Рамстедт зөвшөөрч, тэд хамтдаа Их Хүрээнээс хөдөлсөн, тэгээд зам гудас элдвийг хөөрөлдөх зуур Хайсан Харбинд гарсан анхны монгол бичгийн сонины найруулагчаар хэдэн жил ажилласан тухайгаа дурсаж байсан гэж Рамстедт ярьсан тухай ном бичигт тэмдэглэсэн бий. Эдгээр мэдээллийг үнэмшилгүй болгож байгаа зүйл нь дурдсан он

цагийн ээдрээ юм. Хайсан 1907 онд Их Хүрээнд ирэхээсээ өмнө «Монголын сонин бичиг»-т ажилласан байх бололцоо байхгүй. Уг сониныг Хаант Оросын санхүүгийн дэмжлэгээр Дорнод Хятадын төмөр замын Оросын захиргаанаас эрхлэн 1909 оны 5-р сараас 1918 оны 12-р сар хүртлэх хугацаанд гаргаж байсан юм.

Гэтэл бас Японы эрдэм шинжилгээний сэтгүүлд эрдэмтэн Т.Наками бичихдээ «Хайсан Харбинд байсныхаа дараа Бээжинд На ван (Наянтай байх — Л. Н.)-гийн ордонд алба хааж байсан» гэсэн байна. Энэ мэдээг батлах өөр баримт сэлт олдоогүй байсаар. Монголын хэвлэлийн түүх судлагч, доктор Г.Дэлэг «Харбины монгол сониныг эрхэлж байгсдын дотор Өвөр Монголын Харчин хошууны Алмас-Очир мээрэн, Хайсан гүн нар байв» гээд Хайсанг тус сонины эрхлэгч байсан гэдгийг Б.Ширэндэвийн бичсэнийг баримтлан хэлснээ баталж тусгай зүүлт хадсан байна. Бид дээрх мэдээнүүдээс Хайсан гүн Харбин дахь Оросын консулд, дараа нь «Монголын сонин бичиг»-т ажиллаж, улмаар Ар Монголд ирж үндэсний ардчилсан хувьсгалын үйл хэрэгт оролцсон гэдгийг лавтай мэдэж болно. Харин он цагийг тодруулах шаардлагатай юм. Бидний бодлоор нэгд: Хайсан Харбинээс Бээжинд очиж ажилласан байх цаг хугацааны бололцоогүй, хоёрт: Хайсан Их Хүрээнд 1907 онд ирсэн бол Харбин дахь Оросын консулд дөрвөн жил алба хашаад, дараа нь «Монголын сонин бичиг»-т ажилласан байх үндэслэлгүй байна. Нөгөө талаар Рамстедтийг 1909 онд Ар Монголд ирэхэд Хайсан «Монголын сонин бичиг»-т ажилласан тухайгаа ярьсан байх ёсгүй. Учир нь үүнээс



өмнө уг сонин гарч байгаагүй юм. Энэ зөрөөтэй мэдээлэлд өгөх дараах хоёр хариу байж болно. Нэгд: Рамстедтийн Ар Монголд хоёр дахь удаагаа ирсэн он ташаарсан байж болно, хоёрт: Хайсан 1907 онд байтугай 1909 онд Ар Монголд ирсэн гэдэг нь худлаа. Тэрбээр 1911, бүр эртдээ 1910 оноос өмнө Монголд ирсэн байж гэмээнэ «Монголын сонин бичиг»-т ажилласан байх бололцоотой байна.

Хайсанг Ар Монголд ирсэний дараа түүний орыг залгасан хүн нь Буриадын Агын аймгийн Цэдэвийн Цэдэн-Иш байсан байж болох юм. Богд хааны зараалаар Бээжинд очсон элчин сайд 1916 оны 3-р сард Харбинээр дайрч нутаг буцахад сонины эрхлэгч Ц.Цэдэн-Иш Дээд Үд хүртэл дагаж үдсэн байдаг. Нөгөө талаар 1911 оноос Монголын Нийслэл хүрээнээс Б.Намсрай, Д.Намсрай, Далхжав нарын зэрэг хүмүүс «Монголын сонин бичиг»-т урилгаар болон гэрээгээр ажиллаж эхэлсэн, төдөлгүй Нийслэл хүрээнд Д.Бадрах-баатараар ахлуулсан «Монголын сонин бичиг» сонины сурвалжлах товчоо байгуулагдсан баримтууд анхаарал татаж байгаа юм. Энэ лав 1911 онд Нийслэл хүрээнд ирэнгүүтээ урьд нь өөрөө ажиллаж байсан монгол сониныг ажиллах хүчнээр дутаахгүйн тулд Хайсангийн хийсэн ажил байж болох талтай. Лавшруулж бодвол Ар Монголд өрнөж байсан эрх чөлөөний тэмцлийг илүү үр нөлөөтэй, бодитой тусгуулах зорилгоор Монголын дэвшилт сэхээтэн-сэтгүүлчдийг зориуд илгээх бодлогынх нь үр дүн байсан байж ч болох юм.

Хайсан Ар Монголын тусгаар тогтнолын төлөө Халхын дэвшилт үзэлтэй ноёдтой хамтран тэмцсэн нь түүхэн үнэн

юм. Үүнийг лавтай батлах баримт олон байна.

Тийм баримтын нэг болох түүхч Магсар хурцын бичсэн зүйлд «Харчин ван Гүнсэнноровын хошууны захирагч мэйрэн, эрдэмт түшмэл Хайсан, Алмас-Очир нар Хүрээнд хүрч ирээд газар орны эрх барих монгол лам, ноёдтой уулзаж танилцан, Чин улсын дотоод харгисыг шүүмжилж, ямар аргаар бүх монголчууд нийлэлдэн өөрсдөө хүчирхэг идэрхэг болохыг хэлэлцэвч олдсонгүй. Тэдний хоёр түшмэл Монголын хойд хязгаар, гадаад байдлыг туршиж үзэхээр Хөлөнбуйр, Хайлаар хотын зүг зугаацан одоод Алмас-Очир Хүрээнд эргэж ирсэнгүй, Хайсан явсаар хожим Хүрээнд ирж, Монголын тусгаар тогтнох хэрэгт орролцож явсан» гэжээ.

**Х**айсанг Хүрээнд ирсний дараа Чин улсын Гадаад Монголын төрийг засах явдлын яам мөрдөн тагнаж байсан тул Жибзундамба хутагтын шадар, чин ван Ханддоржийн гэр хороонд нууц байдалтай сууж байжээ. Тэрбээр чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд нартай хамтран Монголыг тусгаар тогтноулах аргыг сүвэгчилж эхэлсэн байна. Түүхт үйл явдлыг нүдээр үзэж байсан ахмад сэтгүүлч Г.Наваан-намжил энэ тухай дурсан бичихдээ «Монголыг Манж улсаас тусгаарлах хэрэгт сэдэвлэж оролцсон Харчины гүн Хайсан улс төрийн бодлоготой бөгөөд манж, хятад, монгол бичигтэй, гадаад улс ба Манж, Хятадын байдлыг мэдэх учир Монголыг тусгаарлах ба Оросын цагаан хаанаас тусламж гуйх хэрэгт да лам Цэрэнчимэдэд идэвхтэй нөхөр жигүүр болж, ихээхэн туслалцаж байсан» хэмээн бичсэн байдаг.



Хайсан Монголын тусгаар тогтнолын гадаад түшиг тулгуур нь Орос улс гэж үзэн, тэдний эрх мэдэлтнүүдтэй холбоо тогтоохыг хичээж оролдсон байна. Тэрбээр юуны өмнө Чин улсын төрийн дарангуйллыг Гаага (Хааг) дахь Олон улсын шүүхэд мэдүүлж, уг хэрэгт Оросын дэмжлэгийг авах, Манжийг дагах дургүй монгол ноёдтой нийлж Богд гэгээнээр толгойлуулсан тусгаар улсыг байгуулах, энэ хэрэгт Оросоос зэр зэвсэг хийгээд, Монголын төрийг төвхнүүлэхэд тусламж хүсэх зэргээр идэвхийлэн зүтгэж байжээ. Энэ хэрэг эс бүтвэл Японоос тусламж гуйхаас өөр аргагүйд хүрч байгаагаа Оросын хурандаа Поповт ярьж байсан тухай ном зохиолд тэмдэглэсэн бий. Хайсан хамтран зүтгэгчдийн хамт Монголын тусгаар тогтнолыг сэргээх төлөвлөгөөгөө 1911 оны хавар Жибзундамба хутагтад айлтган зөвшөөрүүлсний дараа Халхын дээд зиндааны лам, ноёдын нууц зөвлөгөөнд оролцож, улмаар Орос улсад одоо тусламж эрэх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтаж явжээ. Тэд их Орос улсаас зарим талын дэмжлэг олоод буцахдаа Их Хүрээн дэх Манжийн захиргааны мөрдөлтөөс сэрэмжилж хэсэг бүлэг болж, зам буруулан ирцгээсэн байдаг. Хайсан онц ихээр болгоомжлон Эрхүүд үлдэж байгаад Хиагтаар дамжин Их Хүрээнд сэм иржээ. Хиагтад түр саатах завсраа В.Котвичид бичсэн нэгэн захидалдаа «Хиагтад ирсэн даруй Хүрээн дэх да лам Цэрэнчимэдээр

уламжлуулан Богдод хэдэн удаа бичиг бариулж, их хэргийг түргэвчлэн үүсгэх хэрэгтэй. Яавч энэ сайн тухайг алдаж болохгүй гэж шаардан явуулсан билээ. Мөнөө Хүрээнээс хариу ирсэн бичигт их хэргийг нэгэнт үүсгээд, манж амбан Санду ва-г Хүрээнээс мордуулан явуулаад, Халх аймаг анги Монгол улс болж, Богдыг хаанд өргөмжлөхөөр тогтов гэнэ. Хиагтын заргачийг бас мордуулан явуулах бичиг иржээ» гэсэн байна. Тэрбээр

«  
*Хайсан гүн Харбин дахь Оросын консулд, дараа нь «Монголын сонин бичиг»-т ажиллаж, улмаар Ар Монголд ирж үндэсний ардчилсан хувьсгалын үйл хэрэгт оролцсон гэдгийг лавтай мэдэж болно. Харин он цагийг тодруулах шаардлагатай юм.*

»

уг захидлынхаа төгсгөлд «Манай монгол аймаг Их улс (Орос — Л. Н.)-ын онцгой тусламжаар их хэргийг олж үүсгэсэн нь юутай завшаан. Шар, хар нийтээр үл сүслэн шүтэхгүй нь үгүй. Гагцхүү хэргийг үүсгэх нь хялбар, төгсгөх нь бэрх тул Халх газраа одоо цагийн хэргийг боловсон мэдэх эрдэм чадал бүрдсэн хүн маш цөөн учир хожмын хэргийг аль эвтэй сайнаар тогтоож чадахгүйгээс үнэхээр эмзэг болно» хэмээн сэтгэл түвдэж байгаагаа илэрхийлж байжээ.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын дотор Хайсан гүн гадаад хэл, улс төрийн мэдлэгээрээ илт давамгайлж байсан тул бусад нь түүний үгийг анхаарч сонсдог байжээ. Монгол улс тусгаар тогтносны дараахан буюу 1912 оны 1-р сард тусгаар тогтносон Монгол улсыг байгуулах хэрэгт хүчин зүтгэсэн хүмүүсийг хөхүүлэн шагнах тухай Богд хааны зарлигт



«Харчин ван Гүнсэнооровын хошууны дэд зэрэг түшмэл Хайсанд үе улирах чин зүтгэлт цол, улсад туслагч гүн, отго, хүрэн жолоо, жич Халхын дотор улаа шагнаж, Дотоод яамны дэс түшмэлийн оронд тохоон талбигтун!» гэж заасан байна. Зарлигийг ёсоор болгосны дээр Засгийн газраас Хайсангийн хувийн амьдралыг төвхнүүлэхэд онцгой анхаарч 1912 оны хавар улсын сангаас 100 тэмээ бүхий хөсөг гарган өгч, Сэлэнгийн Буур зэрэг зургаан харуулын нутгийг эзэмшүүлж, уул нутгаасаа гэр бүл, садан төрлийнхөө 50 гаруй хүнийг татан авчирч суурьшихыг зөвшөөрсөн байна.

Энэ үеэс Хайсан Ар Монголд ялсан үндэсний эрх чөлөөний хувьсгалыг гүнзгийрүүлэх хэрэгт чин үнэнчээр зүтгэж эхэлжээ. Улс орны эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор 1912 онд байгуулагдсан Орос-Монголын худалдааны нөхөрлөлд хувь нийлүүлсэн, Баруун хязгаарыг Чин улсын ноёрхлоос чөлөөлөх хэрэгт оролцож, уг хязгаарыг төвхнүүлэх сайдад зөвлөн туслах сайдаар томилогдон ажилласан, Ховдын амбан сайдыг буулгаж мал хөрөнгийг хураан цэргийн уналга, хүнсэнд нийлүүлсэн, Гү чэн хо-тоос халдан довтолсон мянга шахам хятад цэргийн өмнөөс сайд Дамдин-сүрэнгийн хамт эсэргүүцэн босч ухраан хөөсөн, 1913 онд Өвөр Монголыг чөлөөлөх таван замын цэрэг хөдөлгөхөд Дарьгангын чиглэлд цэрэг удирдан явсан зэрэг олон гавьяат үйлсийг дурдаж болно. Тэр бүхнийг үнэлж Монгол улсын хааны зарлигаар түүнд түшээ гүний зэрэг шагнасан байна.

Гэвч Ар Монголын улс төрийн хэрэгт зүтгэсэн түүний зам шулуун дардан байгаагүй аж. Хайсанг халх нөхдийнхөө

хамт нутаг нэгтнүүдээ Хятадын хар цэргийн дарангуйллаас чөлөөлөх тэмцэлд оролцож явах хойгуур түүнтэй холбоотой зарга үүсч гэдрэг дуудагджээ. Хааны олгосон нутагт Хайсан орос, хятад хүмүүсийг урьж тариа тариулах, хадлан хадуулах зэргээр шинэ ажил үүсгэсэнд дургүйцэн урьд нь уг нутгийг захирч байгаад Шүүх яамны тэргүүн сайд болсон эрдэнэ чин ван Намсрай зарга мэдүүлсэн байна. Түүнээс гадна Хайсангийн хүү улсад туслагч гүн Буянхишиг зарлигаар олгосон газраас Оросын харьяат нарт тариалангийн талбайг 15 жилээр олгох хэлэлцээр хийсэн, хадсан өвсөө гадагш худалдаж үлэмж ашиг олсон явдал ч нэрмээс болжээ. Бас Гадаад яамны дэд сайд Рашминжүүр газар нутгийн талаар Хайсантай заргалдаж, түүндээ гадаад улсын хүнтэй хуйвалдаж Монголыг Иргэн улсад дагуулах учир гаргасан хэмээн мэдүүлснийг Шүүх яам гүйцэд нягтлалгүйгээр «Улс төрөөс урваж, басхүү бачлан хатгаж бүхий явдал» хэмээн үзэж Хайсанг дайчлан баривчилж, чанга эрүүдэн шүүсэн байна.

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын хамтран зүтгэгч, үнэн журмын нөхөр да лам Цэрэнчимэдийн уйгагүй чармайлтын үр дүнд Хайсанг суллаж, урьдын эрх ямба, хэргэм зэргийг эгүүлэн олгосон хэдий ч түүний улс төрийн зориг хүч ямар нэг хэмжээгээр мөхсөн ажээ. Тэр нь эрдэнэ жүн ван Намсрайтай дахин заалдаж бичсэн нэгэн өргөдөлдөө «Өчүүхэн Хайсан миний бие орших орон, идэх будаагүйн учир гадагш хэсээгүй. Чухам шарын шашин, монгол аймгийг үүрд бататгахын зүг хичээн зүтгэж арваад жил энд тэнд зовон



зүдэрч явсныг дотоод, гадаадын эм хүүхэд хүртэл цөм мэдэх хэрэг. Өчүүхэн миний бие анх түрүүнд Хүрээнээ ирж Монгол тусгаар улс болох их хэргийг нууц гаргаж, Богд эзэнд үүсгэн эхлэх тухай мэдүүлж байхад эрдэнэ жүн ван үхширтэл унтаж, зүүдлээ ч үгүй байсныг хэн ч цөм мэднэ» гэж Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалыг үүсгэн санаачлагчдын нэг байснаа дахин сануулж байснаас тодорхой харагдана. Нөгөө талаар Хайсан цагаадаж ажилдаа эргэн орсон боловч үзэл санаа нийлдэггүй, заргалдсан, гүтгэсэн хүмүүс нь эрхэлсэн ажилдаа хэвээр байсан, Орос, Монгол, Хятад гурван улсын хэлэлцээрээр Монголын тусгаар тогтнолыг эвдэж, өөртөө засах эрхтэй болгосон зэрэг нь түүний урмыг хугалсан байна.

**А**р Монголын тусгаар тогтнолын төлөө хийсэн тэмцэл нь талаар болоход Хайсан 1915 оны эцсээр Харбинээр дамжин Бээжинд буцжээ. Гурван улсын хэлэлцээрт Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэлд оролцсон Дундад иргэн улсын харьяат нарын хэргийг хөөн хэлэлцэхгүй гэсэн заалт орсон нь түүнийг нутагтаа буцахад аян шалтаг болсон байна. Түүнийг Бээжинд очиход Ерөнхийлөгч Юань Ши кай «Сайшаан хүлээн авч, гүнгийн зэрэг шагнаан, замын сүйтгэл таван мянган төгрөг олгосон» тухай «Монголын сонин бичиг» сонин мэдээлсэн, «Чин зүтгэлт Хайсан 1917 онд өвчнөөр нас барсан» тухай «Нийслэл хүрээний сонин»-д бичсэн зэргээс үзвэл тэрбээр ХХ зууны эхэн үед Монгол үндэстний дотроос төрөн гарсан үндэсний эрх чөлөөний төлөө тууштай тэмцэгч, улс төрийн томоохон зүтгэлтэн, нэр нөлөө бүхий хүн байжээ.

Хайсан ном бичигт цагааширсан эрдэмтэн, соён гэгээрүүлэгч хүн байжээ. Тэрбээр Ар, Өвөр Монголын ард түмэнд улс төрийн ухамсар мэдлэг олгоход эрдэм мэдлэгээ зориулж, үндэсний тусгаар тогтнолын үзлийг уйгагүй сурталчилж, өөрийн бие, үйл ажиллагаагаар үлгэрлэж байсан юм. Эрдэмт сэхээтний хувьд Хайсан тухайн үед өөрөө ажиллаж байсан «Монголын сонин бичиг» болон бусад тогтмол хэвлэлд эдийн засаг, улс төрийн сэдвээр гэгээрүүлэх шинжтэй олон зүйл бичсэн байна. Түүний томоохон бүтээлийн нэг нь 1917 онд Бээжинд хэвлүүлсэн «Монгол, хятад бичгээр хавсарсан таван зүгийн ахуу аялгуу бичиг» гэдэг толь бичиг мөн.

Хайсан гүн монгол үндэстний ууган сэтгүүлчдийн нэг мөн. Тэр Буриадын Цэдэн-Иш, Өвөр Монголын Алмас-Очир мээрэн нарын нэг адил Харбинд гарч байсан «Монголын сонин бичиг» сонин орон тооны сурвалжлагч, редактороор ажиллаж байсны зэрэгцээ хожим тус сонин урилгаар Харбинд ажиллаж байсан сэтгүүлч Б.Намсрай, Д.Намсрай, Далхжав болон Нийслэл хүрээн дэх сурвалжлах товчооны ажилтан Д.Бадрахбаатар, Ж.Цэвээн, Д.Бодоо нартай уран бүтээлийн нягт холбоотой ажиллаж байжээ. Хайсан «Монголын сонин бичиг» сонин «Нийслэл хүрээний сонин» гэдэг буланд гол төлөв Манжийн төрөөс Монголын талаар баримталж байсан түрэмгий бодлогыг илчилсэн, Монголын үндэсний эрх чөлөөний тэмцлийг дэмжсэн агуулгатай нийтлэлийг бичиж байжээ. Түүгээр зогсохгүй сүүлд Ж.Цэвээний эрхэлж байсан «Шинэ толь хэмээх бичиг», «Нийслэл хүрээний сонин бичиг» зэрэг сонинд материал бичиж байсан



байж болох сэжүүр гарч байна. Үүнийг цаашид тодруулж нотлох хэрэгтэй юм.

Хайсан гүн бол Монголын төр улсыг сэргээн байгуулах тэмцэлд эр бие, эрдэм мэдлэгээ зориулж явсан тэмцэгч-улс төрч, анхны монгол сониныг редакторлаж байсан ууган сэтгүүлчдийн нэг, тухайн үеийнхээ монгол сэхээтнүүдийн дунд мэдлэг боловсролоороо ааглаж явсан эрдэмтэн хүн байжээ.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бурдуков А. В. 1969. В старой и новой Монголии. М.
2. 1977. «Гакухо» сэтгүүл. №57. Токио.
3. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
4. Жамсран Л. 1992. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. (1911-1913). УБ.
5. 1972. В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ.
6. Магсархурц. Монголын шинэ гарсан түүх. Улсын Төв номын сан. (Гар бичмэл).
7. 1916. «Монголын сонин бичиг» сонин. №177.
8. Навааннамжил Г. 1959. Өвгөн бичээчийн өгүүлэл. УБ.
9. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

10. Норовсүрэн Л. 2005. Монголын нийтлэл. Дэд дэвтэр. УБ.

11. Норовсүрэн Л. 1999. Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүд. УБ.

12. 1984. Өвөр Монголын түүхийн материал. Эмхтгэл-14. (Хятад хэлээр). Хөххот.

13. Улсын түүхийн Төв архив. Фа-6. Хн-511. Б-4.

14. Ширэндэв Б. 1969. Монгол ардын хувьсгалын түүх. УБ.

### Резюме

В настоящей статье автор на основании анализа документов и первоисточников подробно описывает жизнь и творчество графа Б. Хайсана. Он являлся многогранной личностью, который принял деятельное участие в национально-освободительном движении Монголии начала XX века. Б. Хайсан был не только известным политическим и общественным деятелем, но и просветителем, стоявшим у истоков национальной журналистики. Автор предлагает вниманию исследователей редкие документы, относящиеся к журналистской деятельности Б. Хайсана в бытность его сотрудником «Монголын сонин бичиг» («Газета Монголии»). Однако до сих пор существуют множество белых пятен в биографии Б. Хайсана, требующих серьезной проверки.